

Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр  
Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар  
2022 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
<b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>							
1	3.3.6. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	3. Экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ	2021 - 2024		Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 50-аас доошгүй ААН-д хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалтын дэмжлэг үзүүлнэ	Хоршоог хөгжүүлэх сангаас 2022 онд 9 сумын 13 хоршоо, 20 аж ахуйн нэгжид 903 сая төгрөгийн зээл олгож ЖДҮХСангаас Цагаанхайрхан сумын Тэргүүн агьт ХХК, Сантмаргаз сумын Энх дэлгэрэх үйлс ХХК -ийн 137.0 сая төгрөгийн санхүүжилттэй төсөл дэмжигдэж барьцаа хөрөнгийн гэрээ хийгдэж байна. Жижиг дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдэд зориулж Зээлийн батлан даалтын сангийн ажлын хэсгийн баг бүрэлдэхүүн нь 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Батлан даалттай зээлд хэрхэн хамрагдах вэ? сэдэвт сургалтыг зохион байгуулж 35 аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулсан. Зээлийн батлан даалтад Хас банкаар дамжуулан 1, ХААН банкаар дамжуулан 2 аж ахуйн нэгж хамрагдсан байна.	100%
2	3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Ээрэх, нэхэх, сүлжих хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлснээр 100 орчим ажлын байр бий болсон байна.	Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулах, ажлын байр бий болгох зорилгоор Шинэ хөдөө төслийн хүрээнд 149.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар арьс шир, нэхий элдэх тоног төхөөрөмжийг Алдархаан, Асгат, Нөмрөг, Цэцэн-Уул, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан сумын иргэдэд гэрээ байгуулан олгосон. Тоног төхөөрөмжийг гэрээгээр олгосон иргэдэд "Жем руби" ХХК-иас тоног төхөөрөмж түүний ашиглалтын талаар сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд "Эрхэт тунамал" ХХК ноос боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.	100%

3	3.7.4. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно.	5. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна.	2020 - 2024		18 сум	2017 онд НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Дөрвөлжин сумын хөгжлийн төлөвлөгөөг "Вектор меп" ХХК, 2020 онд тус төслийн санхүүжилтээр Их-Уул, Тосонцэнгэл сумыг "Бодлого судлалын төв" хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. 2022 онд НҮБ-ын АДАПТ төслийн санхүүжилтээр Эрдэнэхайрхан, Алдархаан, Отгон зэрэг 7 сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг "Лапланд эко" ХХК гүйцэтгэгчээр шалгарч боловсруулалтын ажил хийгдсэн. Мөн 2023 онд 8 сумд хийхээр санхүүжилтийг батлуулсан.	90%
4	3.7.9. Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ.	8. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна.	2020 - 2024		Түрээсийн орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	150 мянган айл орон сууцны хөтөлбөрт аймагт бүрт 150 айлын орон сууц баригдахаар төлөвлөгдсөн. Улиастай сумын Өлзийт багийн 21-р зуун 800 айлын жишиг хороолол баригдахаар төлөвлөж байгаа бөгөөд хорооллын гадна дулаан, цэвэр, бохир, хэрэглээний халуун усны шугам сүлжээний ажилд 2021 онд 2,5 тэрбум төгрөг батлагдаж шугам сүлжээний ажил хийгдэж дуусч байна. 2021-2022 онд улсын төсөвт цахилгааны хангамжийн ажилд 1,6 тэрбум төгрөг батлагдаж "Техникийн цогц шийдэл" ХХК шалгарч угсралтын ажил дууссан. Улиастай суманд дулааны станц баригдсанаар дулаан, цэвэр, хэрэглээний халуун ус хангагдана тус хорооллын гадна инженерийн шугам сүлжээ ажил хийгдэж дууссанаар 800 айлын орон сууцны хороолол, түрээсийн орон сууц баригдах нөхцөл хангагдана. 2022 оны байдлаар түрээсийн орон сууц баригдаагүй байна.	70%
5	3.7.12. Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	4. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	2021 оны улсын төсөвт Улиастай хотын инженерийн барилга байгууламжийн судалгаа, ТЭЗҮ боловсруулах ажилд 500,0 сая төгрөг батлагдаж Улиастай Богдын гол багийн 1.5 км үерийн далангийн ажлын зураг төсвийг Их мянган инженерчлэл ХХК, Жаргалант, Чигэстэй багийн 5км үерийн далангийн ажлын зураг төсвийг Гидросооружение ХХК тус тус гүйцэтгэж Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. Богдын гол багийн үерийн далангийн ажлын төсөвт өртөг 2.3 тэрбум төгрөг, Жаргалант, Чигэстэй багийн үерийн далангийн ажлын төсөвт өртөг 6.2 тэрбум төгрөг бөгөөд шаардлагатай хөрөнгийн асуудлыг 2023 оны төсөвт тусгуулахаар БХБЯ-нд санал хүргүүлсэн. Санхүүжилт батлагдаагүй тул хийх боломжгүй байна.	70%
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							

6	4.6.3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.	1. Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавина.	2020 - 2024		Сум, дүүргийн орон нутгийн хамгаалалтын 340 төлөвлөгөөг хянаж, тодотгол хийгдэнэ.	Батлан хамгаалахын сайдын 2019 оны 1а/4460 дугаар албан даалгаврын 1 дүгээр заалт, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 1в/345 дугаар албан даалгаврын 6 дугаар заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн 24 сумын "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-нд тусгагдсаны дагуу орон нутгийн хамгаалалтын 4 бүсийн томилгоот нэгжийн бүрэлдэхүүнийг сум бүрээр оногдуулан дансалж, жил бүр тодотгол хийж байна. 2022 онд томилгоот бүрэлдэхүүний тодотголыг 24 суманд хийсэн. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/524 дүгээр захирамж гарч захирамжийн дагуу жил бүр цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын 5 хувийг орон нутгийн хамгаалалтын нөөцөд хуримтлуулах шийдвэр гарсан, хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
7		2. Орон нутгийн хамгаалалтын сургалтын тогтолцоог бүрдүүлэх, томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангана.	2020 - 2024		Орон нутгийн цэрэг, томилгоот нэгжийн 22 сургалт зохион байгуулагдана.	"Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад орон нутгийн хамгаалалтын 4 бүсийн 10 сумангийн захирагч, 24 сумын ЗДТГ-ын дарга нар хамрагдлаа. "	100%

8		3. Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөө, даалгаврыг шинэчилнэ.	2020 - 2024		Нэгдсэн төлөвлөгөө бүрэн хийгдэж, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврын төсөл боловсруулагдсан байна.	Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулагдаж байгаатай холбогдуулан аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг 2022 оны 04 дүгээр сард хүргүүлсэн. Дайчилгааны төлөвлөгөөг дээд шатны байгууллагаас баталж ирүүлээгүй байгаа болно. Улсын дайчилгаа хариуцсан мэргэжилтэн чиг үүргийн дагуу аймгийн нийгэм, эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг шинэчлэн гаргаж батлан хамгаалах яамны улсын дайчилгаа хариуцсан мэргэжилтэнд хүргүүлэн ажиллаж байна. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 1в/2220 дугаар "Хамтран ажиллах тухай" албан бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/62 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг аймгийн Улсын дайчилгааны асуудал хариуцсан мэргэжилтний ажил, нууц баримт бичгийн хадгалалт, хамгаалалтын байдалд заагдсан чиглэлийн дагуу үзлэг явуулж, илтгэх хуудсыг БХЯ-д хүргүүлээд байна.	100%
---	--	---	-------------	--	---	---	------

ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

9	5.1.4. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	1. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.	2020 - 2024		Улаанбаатар хот болон төв суурин газрын 2000-аас доошгүй жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлсэн байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улиастай, Тосонцэнгэл, Их-Уул сумдын гэр хорооллын 7134 айл өрхийн нүхэн жорлонд ариутгал халдваргүйтгэл хийсэн. Тосонцэнгэл сумын Хожуул голын дагуух стандартын шаардлага хангаагүй 14 нүхэн жорлон, Алдархаан сумын Харганы дээд үзүүрийн 3 нүхэн жорлон, Зуслангийн хэсгийн 4 нүхэн жорлон, Ганц модны 1 нүхэн жорлонг ариутгаж дарж, эзэнгүй орхигдсон нүхэн жорлонгийн судалгааг аймгийн хэмжээнд гаргаж, дарж булшлах зөвлөмж чиглэлийг сумдад хүргүүлсэн. Аялал жуулчлалын бүсэд 4 эко ариун цэврийн байгууламж байгуулах ажлыг гэрээ байгуулан гүйцэтгүүлж, 4 ариун цэврийн байгууламжийг хүлээж авсан.	100%
10	5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.	1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	2020 - 2024		Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3 аж ахуйн нэгж 20.71 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 18.5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн. Тосонцэнгэл суманд замын карьерийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 4 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.	100%

11	5.1.11. "Хөх морь" төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	2. Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна.	2020 - 2024		Хөв цөөрмийг 3-аас доошгүй газарт шинээр байгуулах, 120-аас доошгүй булаг шандны эхийг хашиж хамгаалсан байна.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Дөрвөлжин сумын Сайн түрүү, Тосонцэнгэл сумын Хүрэн булгийн эх, Отгон сумын Сайн булаг, Ургамал сумын Баян-Улаан, Яруу сумын Рашаан толгойн рашааныг хамгаалж, тохижуулах ажлыг "Баян ангирт нуур" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, хүлээн авсан. АДАПТ төслөөс 70%, орон нутгийн 30%-ийн хамтарсан санхүүжилтээр Шилүүстэй, Цэцэн-Уул, Сонгино сумдад бага оврын хөв цөөрөм байгуулах ажлыг гүйцэтгэгч шалгаруулсан ч тендер шалгаруулалтад гомдол гаргасан. Түдэвтэй, Шилүүстэй сумдад тохижуулах 2 булгийг хамгаалах ажлыг 2023 онд гүйцэтгүүлэхээр төслөөс шийдвэрлэсэн.	70%
<b>ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>							
12	6.2.5. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.	1. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.	2021 - 2024		Хэрэгжилтийг хангана.	ХХОАТ-ын хуулийн 23.14 дэх хэсэгт заасны дагуу 1353 иргэнд 835.9 сая, ААНОАТ-ын тухай хуулийн 22.1, 22.5.1 28.4 дэх хэсэгт заасны дагуу 10 аж ахуйн нэгжид 72.7 сая төгрөгийн татварын буцаан олголт олгов. 2022 онд Завхан аймагт салбар нэгжээ байгуулах томоохон аж ахуй нэгжийн хүсэлт ирээгүй байна.	100%
13	6.2.8. Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	1. Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрт гэр хорооллын 600-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцлийг сайжруулна.	2020 - 2024		Гэр хорооллын 3000 өрх инженерийн сүлжээнд холбогдсон байна.	2022 онд хувийн хөрөнгө оруулалтаар Улиастай суманд 20 айлын орон сууц ашиглалтад орсон байна. 2020 оны Улсын төсөвт 500.0 сая төгрөг батлагдаж Улиастай сумын гэр хорооллын айл өрхүүдийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлын зураг төсвийг Некст стейп ХХК-д хийлгүүлээд байна. Батлагдсан зураг төсвийн дагуу айл өрхүүдийг үе шаттайгаар шугам сүлжээнд холбогдох ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад хандаж байна. 2019 оны улсын төсөвт 300.0 сая төгрөг батлагдан гүйцэтгэгчээр Зуурмаг ХХК шалгарч, ажлын гүйцэтгэл 80.0 хувьтай байна. Ингэсээр Улиастай сумын Товцог багийн сургууль, цэцэрлэг, өрхийн ЭМТ, багийн хөгжлийн төв, 50 гаруй өрх цэвэр бохир усны шугам сүлжээнд холбогдох нөхцөл бүрдэнэ. 2022 онд Алдархаан, Отгон сумдад "Шинэ сум" төслийн хүрээнд иж бүрэн инженерийн шугам сүлжээг хийж аж ахуйн нэгж 13, айл өрх 55 төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. Улиастай сумд 45, Идэр, Их-Уул, Тэлмэн сумдад тус бүр 12, нийт 81 айлын орон сууцны барилгыг хувийн аж ахуйн нэгжийн санхүүжилтээр барьж ашиглалтад оруулсан.	90%

14	6.2.10. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	1. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	2021 - 2024			Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Улиастай суманд хог хаягдал тээвэрлэх зориулалтын автомашин нийлүүлэх тендер зарлагдсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хог хаягдал шатаах дунд оврын зуух нийлүүлэх ажлын гүйцэтгэгчид шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн Отгон суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хог хаягдал тээвэрлэх 2 төрлийн техник хэрэгсэл энэ оны 12 сард нийлүүлэгдэхээр БНХАУ-ын хил дээр хүлээгдэж байна.	70%
15	6.2.12. Сум, орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ.	1. Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар хангах ажлыг зохион байгуулна.	2021 - 2024		Албаны орон сууцаар хангагдсан байна.	Сумдад ажиллаж байгаа төрийн алба хаагчдын орчин нөхцлийг сайжруулах зорилгоор Огторгуйн цагаан гарьд сан нь Их-Уул, Идэр, Тэлмэн сумдад 12 айлын орон сууцны барилгыг барьж дуусгаад байна. Тус орон сууцанд төрийн албан хаагчид хамрагдаад байна. Мөн Огторгуйн гарьд санийн хөрөнгө оруулалтаар Түдэвтэй, Сонгино сумдад тус бүр 12 айлын орон сууцны барилга эхэлсэн инэгснээр алслагдсан сумдын төрийн албан хаагчид орон сууцаар хангагдах нөхцөл бүрдэнэ. Аймгийн Засаг дарга хилийн 0277 дугаар ангид ажилчдын байр барихад ОНТ-өөс 80 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Ажилчдын байр 10 дугаар сард ашиглалтад орсон.	90%
16	6.2.13. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	1. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	2021 - 2024		Ажлын байр нэмэгдсэн байна.	Хоршоог хөгжүүлэх сангаас Сүү, цагаан идээ үйлдвэрлэх, Фермерийн аж ахуй эрхлэх, Аялал жуулчны бааз өргөжүүлэх, Бетон зуурмагын машин худалдан авах, Чацаргана боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Талх нарийн боов үйлдвэрлэх, Гэр ахуйн тавилга үйлдвэрлэх, Өндөглөгч тахианы аж ахуй эрхлэх чиглэлээр 13 хоршоо, 20 аж ахуйн нэгжид 903 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна. Хөнгөлөлттэй зээлийг олгосноор 25 байнгын, 30 түр ажлын байр шинээр бий болсон байна.	90%

17	6.2.14.. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.	2. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.	2021 - 2024		Дэд бүтцийг бий болгоно.	ХХААХҮЯамнаас 2022 оны 09 дүгээр сарын 18-25-ны өдрүүдэд зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд-2022” үзэсгэлэн худалдаанд хүнсний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Завхан баялаг ХК, Мөнхөд мандаг ХХК, сүү, цагаан идээгээр Анхил дөрвөн баатар ХХК, өрхийн тариаланч Мөнхтөр нарт орон нутгаас дэмжлэг үзүүлж оролцуулсан. Улиастай сумын Богдын гол багт байрлах “ЭМ АР ЭМ ЭС” ХХК-ийн Баян бүрдийн 20тн хүчин чадалтай агуулах шинээр үйл явуулж эхлээд байна. Мөн Номин Холдинг” ХХК-ийн сүлжээ дэлгүүрээр “Мөнхөд мандаг” ХХК бараа бүтээгдэхүүнээ борлуулах гэрээ байгуулан ажиллаж байна. Аймгийн Засаг дарга "Эрдэнэт мах маркет" ХХК -тай санамж бичигт гарын үсэг зурж, Тосонцэнгэл сумын “Завхан мах маркет” ХХК- тай гэрээ байгуулан мал мах бэлтгэн нийлүүлж байна. Улиастай сум, ХХҮХэлтэс хамтран “Алтан намар” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 25 төрлийн хүнсний ногоо, түүхий эд бүтээгдэхүүнийг худалдаалж, 38 тариалан эрхлэгчид оролцон 11.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.	90%